



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 03 дугаар сарын 02  
№09 (1404)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

32.	Хилийн боомтын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах тухай	Дугаар 62	571
33.	Итгэлцүүр батлах тухай	Дугаар 65	582





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 08 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар  
хот

### Хилийн боомтын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын хилийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Хилийн боомтын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Хилийн боомтын Үндэсний зөвлөлийн дүрмийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд, Хилийн боомтын Үндэсний зөвлөлийн дарга Б.Жавхланд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Г.ЗАНДАНШАТАР**

**САНГИЙН САЙД**

**Б.ЖАВХЛАН**



Засгийн газрын 2025 оны 08 дугаар  
сарын 27-ны өдрийн 62 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ХИЛИЙН БООМТЫН ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга: -Сангийн сайд

Гишүүд: -Гадаад харилцааны сайд;  
-Хууль зүй, дотоод хэргийн сайд;  
-Тагнуулын ерөнхий газрын дарга;  
-Хил хамгаалах ерөнхий газрын дарга;  
-Гаалийн ерөнхий газрын дарга;  
-Гадаадын иргэн, харьяатын газрын дарга;  
-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн  
ерөнхий газрын дарга;  
-Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн  
танхимын ерөнхийлөгч (тохиролцсоноор);  
-Монголын логистикийн холбооны тэргүүн  
(тохиролцсоноор).

Нарийн бичгийн  
дарга: -Хилийн боомтын захиргааны дарга.

----oOo----

Засгийн газрын 2025 оны 08 дугаар  
сарын 27-ны өдрийн 62 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

## **ХИЛИЙН БООМТЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Хилийн боомтыг хөгжүүлэх бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус Хилийн боомтын Үндэсний зөвлөл (цаашид “Үндэсний зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагаанд энэхүү дүрмийг баримтална.

1.2.Үндэсний зөвлөл үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын хилийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ дүрмийг удирдлага болгоно.

1.3.Үндэсний зөвлөл Монгол Улсын хилийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

1.4.Үндэсний зөвлөл тухайн хилийн боомт дахь хилийн боомтын зөвлөлийг үйл ажиллагааны чиглэл, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

1.5.Үндэсний зөвлөл зохих журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

### **Хоёр.Бүрэлдэхүүн, зохион байгуулалт**

2.1.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Үндэсний зөвлөлийн даргын санал болгосноор Засгийн газар батална.

2.2.Үндэсний зөвлөлийн дарга нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, нарийн бичгийн дарга нь Хилийн боомтын захиргааны дарга байна.

2.3.Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга (цаашид “Нарийн бичгийн дарга” гэх) Үндэсний зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.

2.4.Үндэсний зөвлөл нь хилийн боомтын хөгжлийн стратеги, төлөвлөлтөд дүн шинжилгээ хийх, нийгэм, эдийн засгийн нөлөөлөл, үр ашгийг тооцох зорилгоор мэргэжлийн судалгааны баг ажиллуулж болно.

### **Гурав.Үндэсний зөвлөлийн хуралдаан**

3.1.Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан (цаашид “хуралдаан” гэх) байна.

3.2.Үндэсний зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд гишүүдийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.3.Хуралдааныг танхимаар, шаардлагатай тохиолдолд цахимаар зохион байгуулна.

3.4.Хуралдааныг Үндэсний зөвлөлийн дарга удирдах бөгөөд даргын эзгүйд түүний томилсон Үндэсний зөвлөлийн гишүүн удирдана.

3.5.Үндэсний зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаанд биечлэн оролцох боломжгүй бол цахимаар оролцох, эсхүл хэлэлцэх асуудлын талаарх саналаа урьдчилан бичгээр гаргана.

3.6.Хуралдаанд шаардлагатай тохиолдолд хэлэлцэх асуудалтай холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

3.7.Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

3.8.Үндэсний зөвлөл бүрэн эрхийнхээ хүрээнд хуралдаанаас тогтоол, зөвлөмж гаргана. Үндэсний зөвлөлийн тогтоол, зөвлөмжид дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

3.9.Нарийн бичгийн дарга хуралдаанд саналын эрхгүй оролцож, хэлэлцэх асуудалтай холбоотойгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.9.1.хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гаргаж, Үндэсний зөвлөлийн даргаар батлуулах;

3.9.2.хуралдааны бэлтгэлийг хангаж, хэлэлцэх асуудалтай холбоотой тооцоо, судалгааг хянан үзэх, баримт бичгийн бүрдлийг хангах;

3.9.3.хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, холбогдох материалыг 3-аас доошгүй хоногийн өмнө Үндэсний зөвлөлийн гишүүдэд хүргүүлж, хуралдааны товыг мэдэгдэх;

3.9.4.хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй гишүүний бичгээр ирүүлсэн саналыг хуралдаанд танилцуулах;



3.9.5.хуралдааны тэмдэглэл хөтлөх, хуралдаанаас гарсан шийдвэрийн төслийг ажлын 5 хоногт багтаан албажуулан, баталгаажуулах, шийдвэрийг холбогдох байгууллага, Үндэсний зөвлөлийн гишүүдэд хүргүүлэх;

3.9.6.Үндэсний зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг холбогдох байгууллагаас авч нэгтгэн, тайлан, дүгнэлтийг Зөвлөлийн хуралдаанд улирал бүр танилцуулах;

3.9.7.Үндэсний зөвлөлийн албан хэрэг хөтлөлтийг холбогдох журмын дагуу гүйцэтгэх, хадгалалт, хамгаалалтыг хариуцах.

### **Дөрөв.Бусад зүйл**

4.1.Хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбоотой төрийн болон албаны нууцад хамаарах асуудлыг задруулах, хуралдааны шийдвэр баталгаажих хүртэл аливаа мэдээллийг бусдад тараахыг хориглоно.

4.2.Үндэсний зөвлөл хуульд заасан бүрэн эрх, энэ дүрэмд заасан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ хилийн хяналтын байгууллагуудын хяналт шалгалтын чиг үүрэгт оролцох, шийдвэр гаргах, хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

4.3.Үндэсний зөвлөлөөс гаргасан шийдвэрийг төрийн холбогдох байгууллагууд хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтийг хангах чиглэлээр дотоод зохион байгуулалтын арга хэмжээ авах, ажлын уялдаа холбоог хангаж хамтран ажиллах үүрэгтэй.

----o0o----



Хэргийн үйл явдлын үргэлжлэл  
Хэргийн үйл явдлын үргэлжлэл  
Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл  
Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл

Хэргийн үйл явдлын үргэлжлэл

-----000-----











## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 08 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар  
хот

### Итгэлцүүр батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход 2026 онд хэрэглэх итгэлцүүр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж тогтоох, цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2011 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолд заасан сарын дүнг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар, мөн өдрөөс хойш 2023 оныг дуустал хугацаанд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших хугацаанд албан журмын даатгуулагчийн хувьд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тус тус тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Г.ЗАНДАНШАТАР**

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД**

**Т.АУБАКИР**

Засгийн газрын 2025 оны 08 дугаар  
сарын 27-ны өдрийн 65 дугаар  
тогтоолын хавсралт

**ДААТГУУЛАГЧИЙН ШИМТГЭЛ ТӨЛӨХ БОЛОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ  
ТОГТООЛГОХ ЦАЛИН ХЭЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГЫН  
ӨНӨӨГИЙН ҮНЭ ЦЭНИЙГ ТОДОРХОЙЛОХОД  
2026 ОНД ХЭРЭГЛЭХ ИТГЭЛЦҮҮР**

<b>Он</b>	<b>Итгэлцүүр</b>
1990 он ба түүнээс өмнөх он	3066.86
1991	1534.70
1992	802.85
1993	352.19
1994	213.09
1995	71.88
1996	54.62
1997	46.05
1998	36.63
1999	31.92
2000	26.98
2001	25.70
2002	22.37
2003	19.80
2004	17.41
2005	15.99
2006	12.99
2007	9.82
2008	6.52
2009	6.02
2010	5.30
2011	4.40
2012	3.48
2013	2.67
2014	2.53
2015	2.39
2016	2.21
2017	1.98
2018	1.77



2019	1.60
2020	1.52
2021	1.33
2022	1.18
2023	1.09
2024	1.00

---o0o---

Үзүүлэлт, үндэсний үнэмлэхүй гүйцэтгэл, үнэмлэхүй үнэмлэхүй

2026 он 09 сар 10 - 15 өдөр

Хурал

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН  
УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН  
МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН

Хурлын үндэсний үнэмлэхүй гүйцэтгэл

1. «МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН»-ийн үндэсний үнэмлэхүй гүйцэтгэл, үнэмлэхүй үнэмлэхүй

2. «МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН»-ийн үндэсний үнэмлэхүй гүйцэтгэл, үнэмлэхүй үнэмлэхүй

3. «МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН»-ийн үндэсний үнэмлэхүй гүйцэтгэл, үнэмлэхүй үнэмлэхүй

4. «МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН»-ийн үндэсний үнэмлэхүй гүйцэтгэл, үнэмлэхүй үнэмлэхүй

Үзүүлэлт, үндэсний үнэмлэхүй гүйцэтгэл, үнэмлэхүй үнэмлэхүй

Хурал

Хурлын үндэсний үнэмлэхүй гүйцэтгэл, үнэмлэхүй үнэмлэхүй

Хурал



дээрх мэдээлэл нь 2025 оны 10 сарын  
15-ны өдөр болон 16 сарын 15-ны өдөр  
өгөгдсөн мэдээлэл дээр үндэслэн

• 2025 оны 10 сарын 15-ны өдөр болон  
16 сарын 15-ны өдөр өгөгдсөн мэдээлэл  
дээр үндэслэн 2025 оны 10 сарын 15-ны өдөр  
болон 16 сарын 15-ны өдөр өгөгдсөн мэдээлэл  
дээр үндэслэн

Мэдээлэл	Мэдээлэл
2025.06.01	2025.06.01
2025.06.02	2025.06.02
2025.06.03	2025.06.03
2025.06.04	2025.06.04
2025.06.05	2025.06.05
2025.06.06	2025.06.06
2025.06.07	2025.06.07
2025.06.08	2025.06.08
2025.06.09	2025.06.09
2025.06.10	2025.06.10
2025.06.11	2025.06.11
2025.06.12	2025.06.12
2025.06.13	2025.06.13
2025.06.14	2025.06.14
2025.06.15	2025.06.15
2025.06.16	2025.06.16
2025.06.17	2025.06.17
2025.06.18	2025.06.18
2025.06.19	2025.06.19
2025.06.20	2025.06.20
2025.06.21	2025.06.21
2025.06.22	2025.06.22
2025.06.23	2025.06.23
2025.06.24	2025.06.24
2025.06.25	2025.06.25
2025.06.26	2025.06.26
2025.06.27	2025.06.27
2025.06.28	2025.06.28
2025.06.29	2025.06.29
2025.06.30	2025.06.30





**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [tugii\\_medeel@parliament.mn](mailto:tugii_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

**Индекс: 200003**